



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д. Сүхбаатарын талбай 7,  
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160 0035  
Утас: (976-11) 32 71 99  
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024. 05. 18 № 03 | 2741  
таний -ны № -т

### Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан “Телекамерийн нэгдсэн төвийн техник, тоног төхөөрөмж, систем, программ хангамж (Улаанбаатар хот)” НЗДТГ/20240102009 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой “Бодь-Электроникс” ХХК-иас 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

1. Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д “Багц 1, 2-ын барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана” ... дээрх ИТА-ыг давхцуулахгүйгээр, тухайн төсөл арга хэмжээнд тушаалаар томилсон байна.” гэж заасан байна. Тус шаардлагын дагуу бид 1 ажилтанг 2 өөр албан тушаалд давхар санал болгож болохгүй гэж ойлгож байх бөгөөд багцуудын дунд бүх ИТА ижил байх боломжтой гэж уншигдаж байна.

Иймд, бид багцуудын дунд ижил боловч 1 хүнийг 2 өөр албан тушаалд давхцуулахгүйгээр санал болгосон тохиолдолд шаардлагад нийцсэн гэж үзэх эсэх;

Хариулт: Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д “Багц 1, 2-ын барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана” ... дээрх ИТА-ыг давхцуулахгүйгээр, тухайн төсөл арга хэмжээнд тушаалаар томилсон байна. Санал болгож буй удирдах, инженер техникийн ажилчдын 60-аас доошгүй хувь нь үндсэн ажилтан байх бөгөөд Төслийн удирдагч, Ерөнхий инженер, ХАБЭА нь заавал тухайн компанийн үндсэн ажилтан байна” гэж заасан тул тус тендер шалгаруулалтын тухайн багц төсөл арга хэмжээнд ИТА-ыг давхцуулахгүй, харин хоёр багц төсөл арга хэмжээнд давхцуулж болно.

2. Тус тендерийн Багц-1, Багц-2 тус бүрийн техникийн тодорхойлолтоос үзэхэд модель заасан боловч “эсхүл дүйцэхүйц” гэх нэр томьёо бичигдээгүй байна.

Тендерийн баримт бичгийн хүрээнд үйлдвэрлэгчийн зөвшөөрөл шаардсан тул бид ТШЗ-ын 28 дугаар зүйлд заасны дагуу хуулийн 26 дугаар зүйл дэх журмыг баримтлан техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлттэй дүйцэхүйц бараа санал болгосон тохиолдолд шаардлагад нийцсэн гэж үзэх эсэх;

Хариулт: Тус тендерийн Багц-1, Багц-2 тус бүрийн техникийн тодорхойлолт, шаардлагыг бүрэн хангасан, илүү хангаж байгаа тохиолдолд шаардлагад нийцсэн гэж үзнэ. Мөн ТШЗ 20.1-д Санал болгож буй систем, ухаалаг программ хангамж, хяналтын камерууд болон сервер, сүлжээний салаалагч төхөөрөмжүүд, шилэн кабель, ханан дэлгэц, генератор дээр үйлдвэрлэгчийн албан ёсны зөвшөөрөл шаардана гэж заасан болно.

3. Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын 27 дахь ажил болох “Засварын ажил” буюу хяналтын өрөө, серверийн өрөө, хурлын заал, алба хаагчдын оффис өрөөнүүдийн талбайн нарийвчилсан хэмжээг тодорхой болгох;

1110202445

**Хариулт:** Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын дэргэд байгуулах “теле камерын хяналтын дэд төв”-ийн байрны зохион байгуулалт (одоо байгаа), байршил, барилгын хийц нь харилцан адилгүй бөгөөд ханан дэлгэц бүхий хяналтын өрөө, тоног төхөөрөмж байрлуулах серверийн өрөөг бүрэн засварлана. Ханан дэлгэц бүхий хяналтын өрөөний хэмжээ өйрөлцөогоор 10x13 метр байх ба тоног төхөөрөмж байрлуулах серверийн өрөө нь бүх метрийн хэмжээтэй байна. Хана нураах, өрөх, хаалга суурилуулах ажил гарна. Шаардлагатай тохиолдолд бусад өрөөнүүдэд өнгөц засвар хийж болно. “Теле камерын хяналтын дэд төв”-ийн байр тодорхой болсон тул газар дээр нь очиж танилцах бүрэн боломжтой болно.

4. Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын 28 дахь ажил болох “Шилжүүлэх ажил” буюу Цагдаагийн хэлтсээс дэд төв рүү тоног төхөөрөмж зөөх ажлын цар хүрээ болон тоног төхөөрөмж шилэн кабелийн тоо хэмжээг тодорхой болгох;

**Хариулт:** Дүүргийн цагдаагийн хэлтсүүдийн байранд телекамер, хяналтын системийн тоног төхөөрөмжүүд байрладаг бөгөөд шаардлагатай бичлэгийн төхөөрөмж, сүлжээний салаалагч төхөөрөмжүүдийг шилжүүлнэ. Мөн Цагдаагийн хэлтсийн байранд 2-оос 4 ширхэг 42U-ийг зогсуур байгаа бөгөөд одоо гудамж, зам, талбайд байрлуулсан телекамерын шилэн кабелийн (12-96шөрмөс) холболтыг шилжүүлэх ажил хийгдэх ба “Теле камерын хяналтын дэд төв”-ийн байр тодорхой болсон тул газар дээр нь очиж танилцах бүрэн боломжтой болно.

5. Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын 29 дэх ажил болох “Цахилгааны үндсэн холболтын шинэчлэх” гэдэгт яг ямар ямар ажил тусгагдаж байгааг тодорхой болгох;

**Хариулт:** Тухайн сонгогдсон “Теле камерын хяналтын дэд төв”-ийн барилга, байгууламжийн үндсэн тэжээлийн оруулгын тоноглолтыг шинэчилнэ. Олон жил ашигласан, бага чадлын таслагчуудтай тул шинэчлэх шаардлагатай. Мөн зарим барилгын 380В-ийн цахилгааны оруулгыг шинэчлэх шаардлагатай. “Теле камерын хяналтын дэд төв”-ийн байр тодорхой болсон тул газар дээр нь очиж танилцах бүрэн боломжтой болно.

6. Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын 30 дахь ажил болох “Ширээ сандал” буюу дэд хяналтын өрөөнд байрлах тавилгуудын тоо хэмжээ, тавилгын хэмжээсийг тодорхой болгох;

**Хариулт:** “Теле камерын хяналтын дэд төв”-ийн ханан дэлгэц бүхий хяналтын өрөөний операторын ширээ, сандал 4 иж бүрдэл, тухайн өрөөнд байрлах хурлын ширээ, болон инженер, техникийн ажилчдын оффис ширээтэй байхаар санал ирүүлнэ.

7. Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын №2.2.1. Ухаалаг программ хангамж нь: Нийт 9 дүүрэгт хуваарилсан тоо хэмжээг заасан байна. Эдгээр 9 дүүргийн тусдаа ажиллах системүүдийг нэгдсэн удирдлагад нэгтгэх систем шаардлагатай эсэх;

**Хариулт:** “Нийслэлийн нэгдсэн удирдлагын төв”-өөс “Теле камерын хяналтын дэд төв”-үүд дээр суурилуулсан дүрс бичлэгт боловсруулалт хийх, ухаалаг программ хангамжийн систем”-үүдийг нэгтгэн хянаж удирдахаар системийн зохион байгуулна.

“Теле камерын хяналтын дэд төв”-үүд дээр суурилуулсан “дүрс бичлэгт боловсруулалт хийх, ухаалаг программ хангамж”-үүдад цугласан эвентүүдийг хамгийн бага сүлжээний зурвасын өргөнөөр хүлээж авах, дамжуулах боломжтой байхаар техникийн шийдэл боловсруулан ирүүлнэ.

“Нийслэлийн нэгдсэн удирдлагын төв”-өөс бүх дэд төвүүд рүү хүн болон тээврийн хэрэгслээр хар, цагаан жагсаалт үүсгэж, нэгэн зэрэг зарлан мэдээлэх, дэд төвөөсөө буцааж мэдээлэх, дэд төвүүдэд хадгалагдсан эвентүүдийг татан авч нэгтгэж харах, тайлан гаргах, удирддаг байна.

8. Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын №2.2.2. Видео удирдлагын нэгдсэн систем нь: Нийт 9 дүүрэгт хуваарилсан тоо хэмжээг заасан байна. Эдгээр 9 дүүргийн тусдаа ажиллах системүүдийг нэгдсэн удирдлагад нэгтгэх систем шаардлагатай эсэх;


Хариулт: "Нийслэлийн нэгдсэн удирдлагын төв"-өөс "Теле камерын хяналтын дэд төв"-үүд дээр суурилуулсан видео удирдлагын системийг нэгдсэн хянаж удирдахаар системийг зохион байгуулна.

"Теле камерын хяналтын дэд төв"-ийн видео удирдлагын системд холбогдсон теле камеруудаас "Нийслэлийн нэгдсэн удирдлагын төв" холбогдож харах бөгөөд шаардлагатай тохиолдолд 200 күртэл теле камерын бичлэгийг хийх боломжтойгоор системийн шийдлийг зохион байгуулна.

9. Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын №2.2.1. болон №2.2.2. дахь хоёр системүүд нэгдсэн удирдлагад нэгтгэгдэх бол шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн мэдээллийг тус тус тодорхой болгож, тодруулгын хариуг ирүүлж өгнө үү.

Хариулт: "Теле камерын хяналтын дэд төв"-д ажиллаж байгаа дүрс бичлэгт боловсруулалт хийх ухаалаг программ хангамж, видео удирдлагын системийг "Нийслэлийн нэгдсэн удирдлагын төв"-өөс нэгтгэж хянах, удирдаж зохион байгуулах ба сүлжээний хамгаалалтын төхөөрөмж нь техникийн тодорхойлолтод тусгагдсан BDL1-A2600-IN36, сүлжээний үндсэн төхөөрөмжийг 40Gb байхаар техникийн шийдлийг боловсруулж ирүүлнэ. Программ хангамжийн техникийн тодорхойлолтын 2.2.1-ийн Шийдэл:...хэсэгт заасан программ хангамж, системтэй дүйцэх шийдлээр санал болгож ирүүлнэ.

ДАРГА



Л.ХОСБАЯР